



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 5 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 154

Улаанбаатар
хот

**“Эрдэнэс Монгол” ХХК болон түүний охин
компанийн талаар авах зарим арга
хэмжээний тухай**

Компанийн тухай хуулийн 16.2.2, 62.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааг сайжруулж, Оюутолгой, Тавантолгой зэрэг стратегийн ач холбогдол бүхий ордын үр ашгийг иргэн бүрт хүртээмжтэй болгох зорилгоор “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрэм болон үйл ажиллагааны стратегийг шинэчлэн боловсруулж батлуулах, шаардлагатай бол холбогдох зарим хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулан шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Даажамба)-д даалгасугай.

2. Монгол Улсын хүн амын өсөлттэй уялдуулан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн давуу эрхийн хувьцааг нэмэгдүүлж, Монгол Улсын иргэн бүрт эзэмшүүлсэн нэг ширхэг давуу эрхийн хувьцааны бүртгэлийг баталгаажуулах арга хэмжээ авахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Даажамба), “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Лхагвад даалгасугай.

3. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг аж ахуйн нэгжид худалдсан болон уг хөрөнгийг банкинд байршуулсны хүүгийн орлогоор Хүний хөгжил санд 2014 онд төвлөрч, урьдчилж орсон орлогоор бүртгэгдсэн нийт 7,948,753,689.17 (долоон тэрбум есөн зуун дөчин найман сая долоон зуун тавин гурван мянга зургаан зуун наян есөн төгрөг арван долоон мөнгө) төгрөгтэй тэнцэх мөнгөн хөрөнгийг тусгаарлан арилжааны банкинд гэрээний үндсэн дээр байршуулахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд даалгасугай.

4. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааны бүртгэлийн асуудал шийдвэрлэгдсэний дараа энэ тогтоолын 3 дугаар зүйлд заасан хөрөнгийн үлдэх хэсгийг 2016 онд хэрэгжүүлсэн “Сайн хувьцаа” арга хэмжээнд зориулан гаргасан Засгийн газрын үнэт цаасны төлбөрийг төлөхөд зарцуулахыг Сангийн сайд Б.Чойжилсүрэнд зөвшөөрсүгэй.

5. Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийн “а”, “б” заалт, Засгийн газрын 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 116 дугаар тогтоолын дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг худалдан авсан аж ахуйн нэгж хүсэлт гаргасан тохиолдолд 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөр тасалбар болгон тэдгээрийн хувьцааг энэ тогтоолын 3 дугаар зүйлд заасан хөрөнгөөс буцаан худалдан авч, төрийн эзэмшлийн хувьцаанд нэмэгдүүлэн бүртгэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Лхагва нарт тус тус даалгасугай.

6. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нийт 15 тэрбум хувьцааны 80 хувь буюу 12 тэрбум ширхэг хувьцааг гаргасан хувьцаагаар, 20 хувь буюу 3 тэрбум ширхэг хувьцааг зарласан хувьцаагаар компанийн дүрэмд тусгаж бүртгэхийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (У.Бямбасүрэн)-д даалгасугай.

7. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрөл бүхий ордуудыг олон улсын аргачлалын дагуу 2018 онд багтаан үнэлүүлэх арга хэмжээ авч,

цаашид "Эрдэнэс Монгол" ХХК болон түүний охин компанийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрөл бүхий ордуудыг үнэлж, компаниудын үнэлгээг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Даажамба)-д даалгасугай.


8. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Р.Содхүү, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын дарга Б.Нямдаваа, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Түмэнцогт, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн гүйцэтгэх захирал Д.Ариунболд, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ш.Лхагва нарт тус тус даалгасугай:

8.1. Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас ирүүлсэн мэдээллийг үндэслэн "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцаанаас хишиг хувь хүртсэн болон Засгийн газарт нэрлэсэн үнээр хувьцаагаа худалдсан иргэдийн хувьцааг төрийн мэдлийн хувьцаанд нэмэгдүүлэн бүртгэж, шинээр хувьцаа эзэмших болон хувьцаагаа буцаан худалдан авах хүсэлт гаргаж төлбөрөө шилжүүлсэн иргэдийн хувьцааг төрийн мэдлийн хувьцаанаас шилжүүлэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг цэгцлэх ажлыг 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн дотор хэрэгжүүлэх;

8.2. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн хувьцаа эзэмшигчийн бүртгэлийг үндэслэн хувьцааны нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тооцож, нийт гаргасан хувьцааг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн санхүүгийн тайланд тусгах;

8.3. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг "Эрдэнэс Монгол" ХХК-ийн нэр дээр бүртгэж, нэрлэсэн үнийг 933 төгрөгөөр тооцож, санхүүгийн тайланд тусгах.

9. Хөгжлийн банкнаас олгосон "Эрдэнэс Монгол" ХХК-ийн 170.6 тэрбум төгрөгийн зээлийн өрийг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаагаар солих, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн 200 сая ам.долларын зээлийг бэлэн мөнгөөр төлж барагдуулах, эсхүл "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн төрийн мэдлийн хувьцаагаар солих хувилбарын талаар санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулахыг Хөгжлийн банкны болон "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Даажамба)-д даалгасугай.



Ж.ЭРДЭНЭБАТ

Ж.МӨНХБАТ